УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН ТУШААЛ

2018 оны 11 сарын 30 өдөр Дугаар А/315 Улаанбаатар хот

Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны 02/22 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2018 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн "Тээврийн хэрэгслийн жишиг зогсоолыг нэмэгдүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай" А/1063 дугаар захирамж, Нийслэлийн Засаг даргын 2014 оны А/279 дүгээр захирамжаар батлагдсан "Захирамжлалын баримт бичиг боловсруулах, батлах, хянах, мэдээлэх журам"-ын 2 дугаар хэсгийн 2.4.1, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар хэсгийн 2.9.5, 3 дугаар хэсгийн 3.1.21 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Сүхбаатар дүүргийн 1 дүгээр хорооны нутаг дэвсгэр, Тээврийн цагдаагийн албаны зүүн урд талд байрлах нийтийн эзэмшлийн зам талбайд 48 автомашины багтаамж бүхий ухаалаг, төлбөртэй тээврийн хэрэгслийн давхар зогсоол байгуулах ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнийг хавсралт ёсоор байгуулсугай.

2. Дээрх ажлыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулж, гүйцэтгэлд хяналт тавьж, ашиглалтад хүлээн авах ажлыг холбогдох дүрэм, журмын дагуу зохион байгуулахыг Аудит, дотоод хяналтын хэлтэс /Ц.Рэгзэдмаа/-т үүрэг болгосугай.

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ
ДАРГА Т.ГАНТӨМӨР

D:\backup_old_pc\Work documents\doc 2018\Тушаал doc 2018.docx

1110301098

Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн
2018 оны 11 сарын 30 өдрийн
А/316 тушаалын хавсралт

ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

Дарга	Т.Хэрлэн	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Инженерийн байгууламжийн хэлтсийн дарга
Гишүүд	Р.Даваасүрэн	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Инженерийн байгууламжийн хэлтсийн ахлах мэргэжилтэн
	П.Чойжилжав	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Аудит, дотоод хяналтын хэлтсийн мэргэжилтэн
	Ц.Бямбажав	Баянзүрх дүүргийн 12 дугаар хорооны иргэн /зөвшилцсөнөөр/
Нарийн бичгийн дарга	Б.Мөнхзул	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Инженерийн байгууламжийн хэлтсийн мэргэжилтэн